77	2.4. Эрчим хүчний найдвартай, аюулгүй тогтвортой байдлыг хангана.	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Завханмандал сумын "Ногоон хэрэм"-ийн туслах зурваст усалгааны зориулалтын ЦДАШ татах	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	0	100%	50.0	ОНХС	50.00	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, БОАЖГ, Завханмандал сумын ЗДТГ	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Завханмандал сумын Засаг даргад эрх шилжүүлж "Ногоон хэрэм"-ийн туслах зурваст усалгааны зориулалтын ЦДАШ татах ажилд "Домч эгэл бор" ХХК шалгарч зураг төслийн дагуу 0,4 кВ-ын шугамыг 1,2 км газарт татаж ашиглалтад оруулсан.	100
78		Улиастай сум дахь шороон замын тэгшилгээ хийх, засварлах	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	0	100%	100.0	ОНЗС		АЗДТГ-ын ХБТХОХ	Улиастай сумын ЗДТГ	Гүйцэтгэгчээр "Эко энерги ресурс" ХХК шалгарч, ажлыг гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.	100
79		Яруу сумын Нарийн давааг засварлах	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	0	100%	45.2	ОНХС	45.17	АЗДТГ-ын ХБТХОХ	СЗДТГ	Гүйцэтгэгчээр "Жинчин гранд" ХХК шалгарч гэрээ байгуулан, ажлыг гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.	100

80	2.5. Улсын болон орон нутгийн авто замын сүлжээг өргөжүүлнэ.	Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан зам давааг засварлах /энэ хэсэгт аймгийн ИТХ-ын 80 дугаар тогтоолоор 202.5 сая төгрөг нэмэгдүүлсэн/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	0	100%	471.9	ОНЗС		АЗДТГ-ын ХБТХОХ	СЗДТГ	Аймгийн 100 жилийн ойн хүрээнд Улиастай сум дахь зам, замын байгууламжид засвар үйлчилгээ хийж, шинээр зогсоолууд барьж байгуулсан. 58,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Улиастай сумын Жинст багийн Холбооны 27-р байрны хойд хэсгийн зогсоолын ажлын гүйцэтгэгчээр "Энх энэрлийн өргөө" ХХК шалгарч бетон хучилтыг үйлдвэрийн үзэлийн бетон зуурмагаар 20см зузаан цутгаж хийсэн. 100м2 орон сууцны дагуу явган замыг чанарын шаардлага хангасан лабораторийн сертификаттай явган замын хавтан болон авто бродюраар хийж гүйцэтгэсэн. 55,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Улиастай сумын Жинст багийн Завхан буудлын баруун талын зогсоол хийх ажлын гүйцэтгэгчээр "Ингүүмэл зам" ХХК шалгарч 33.6 м2 явган хүний замыг өнгөт хавтангаар хийж гүйцэтгэж байна. Зогсоолын цутгалтын ажил нь хавар хийгдэхээр хойшлогдсон. "Мигаа дэвших" ХХК-тай 20 сая төгрөгийн гэрээ байгуулан, Улиастай захын зүүн талын шовгоруудын урд талын 372м2 талбайг бетоноор цутгаж, хүлээлгэн өгсөн. Мөн 20,0 сая төгрөгийн гэрээ байгуулан Чандмань авто жолооны сургуулийн завсрын хэсэгт 264м2 талбайг 12-20 см-ийн зузаантай, 5-7 см-ийн налууутай бетоноор цутгаж хүлээлгэн өгсөн. "Мигаа дэвших" ХХК-тай 20,0 сая төгрөгийн гэрээ байгуулан Цахир дэлгүүр болон авто сэлбэгийн дэлгүүрийн хэсэгт 12-20 см-ийн зузаантай 252 м2 талбайг бетоноор цутгаж, ажлыг хүлээлгэн өгч ашиглалтад оруулсан.	100
81		Нутгийн удирдлагын ордны зүүн талын машины зогсоолыг засварлах	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	0	100%	80.0	ОНЗС		АЗДТГ-ын ХБТХОХ	Улиастай сумын ЗДТГ	Гүйцэтгэгчээр "Эко эвсэг зам" ХХК шалгарч ажлыг гүйцэтгэсэн. Комисс ажиллаж өнгөлгөөний 0,02-0,03 м зузаантай нэмэлт хучилт болон тэмдэг, тэмдэглэгээ хийх шаардлага хүргүүлсэн.	90
ХОЁРДУГААР БҮЛГИЙН ДУНДАЖ												81.16	
3. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО													
82		Оны тэргүүний хэлтэс, агентлаг, сум, баг, албан хаагчдыг шалгаруулах	2023 он	Тэргүүний хэлтэс, агентлаг, сум, албан хаагчдын тоо	Тэргүүний албан хаагчаар 9 албан хаагч, "Шилдэг сум" 5, "Шилдэг баг" 5, "Шилдэг байгууллага" 5 шалгарсан.	Тэргүүний албан хаагчаар 9 албан хаагч, "Шилдэг сум" 5, "Шилдэг баг" 5, "Шилдэг байгууллага" 5 шалгаруулах	10.0	ОНТ	34.07	АЗДТГ-ын ТЗУХ	АЗДТГ-ын ХШҮХ	Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, холбогдох журам заавруудыг үндэслэн "Шилдэг сум" 5, "Шилдэг баг" 1, "Шилдэг байгууллага" 9, Тэргүүний албан хаагч 9, оны онцлох хүн 1 шалгаруулан Засаг даргын 2023 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн А/50 захирамжаар шагнаж урамшуулсан.	100

83	"Төрийн бүтээмжийн сэргэлт"-ийн хүрээнд Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих	2023 он	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь		0%	100%	5.0	ОНТ	5.00	АЗДТГ-ын ТЗУХ	Байгууллагууд	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, чиг үүргийн дагуу хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллаа. Засгийн газар, Төрийн албаны зөвлөл, холбогдох дээд шатны байгууллагуудаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг орон нутагт ханган ажиллаж, ерөнхий шалгалтыг 4 удаа, нутгийн захиргааны байгууллагуудын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг 6 удаа зохион байгуулсан. 2023 онд төрийн үйлчилгээний удирдах 23, төрийн захиргааны удирдах 11, төрийн захиргааны гүйцэтгэх 106, төрийн захиргааны туслах 4 ажлын байр тусгай шалгалтын үр дүнд нөхөгдсөн байна. Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарласантай холбогдуулан Төрийн албаны тухай хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлж, "Шүүр" ажиллагааны хүрээнд удирдамж, төлөвлөгөө гарган аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, сумдад ажиллаж, заавар зөвлөмж, өгч холбогдох арга хэмжээг авч илэрсэн зөрчил дутагдлыг арилгах зохион байгуулалтын арга хэмжээ авч, ажиллаж байна.	100
84	Үндэсний их баяр наадам Ардын хувьсгалын 102, Завхан аймаг үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэх /энэ хэсэгт аймгийн ИТХ-ын 80 дугаар тогтоолоор 318.5 сая төгрөг нэмэгдүүлсэн/	2023 он	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь	Ардын хувьсгалын 100, 101 жилийн ойн Үндэсний их баяр наадмыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан.	100%	818.5	ОНХС	818.50	АЗДТГ-ын ТЗУХ	Байгууллагууд	Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр захирамжаар Завхан аймаг үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх, бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах аймгийн хороо, салбар хороодыг байгуулсан. Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан 11 салбар хороод бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний хэрэгжилтийг 7 хоног бүр аймгийн Засаг даргад танилцуулан хэрэгжилтийг тайлагнаж ажилласан. Аймгийн 100 жилийн ойн баяр наадмыг Засгийн газраас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу тогтсон хугацаанд 2023 оны 7 сарын 26-28-ны өдрүүдэд ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлсэн.	100	
85	Шинээр байгуулагдсан Цахим хөгжлийн хэлтэст тоног төхөөрөмж авах /энэ заалт аймгийн ИТХ-ын 69 дүгээр тогтоолоор нэмж батлагдсан/	2023 он	Тоног төхөөрөмжийн тоо	0	4	10.0	ОНТ1	10.00	АЗДТГ-ын ТЗУХ	Цахим хөгжлийн хэлтэс	Завхан аймаг дахь төрийн цахим үйлчилгээний хэлтэс байгуулагдсантай холбоотойгоор тус хэлтэст зөвөрийн компьютер, өнгөт принтер, интернэт сүлжээ дамжуулах зөвөрийн төхөөрөмж, 3 үйлдэлт принтер, IP камер зэрэг тоног төхөөрөмж, шаардлагатай программын дэмжлэг үзүүлсэн.	100	
86	Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах /энэ заалт аймгийн ИТХ-ын 80 дугаар тогтоолоор нэмж батлагдсан/	2023 он	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь	100%	100%	100.0	ОНТ	100.00	АЗДТГ-ын ХБТХОХ	ИНБ, холбоодууд	Аймгийн ахмадын хороо, Тосонцэнгэл, Их-Уул сумдын ахмадын хороотой хамтран ахмадын баяр, ахмадын уулзалт зохион байгуулахад зориулж 71.0 сая төгрөг зарцуулсан. Мөн Уяачдын холбоо, Оёдолчдын холбоо, Урчуудын эвлэлийн Завхан аймаг дахь салбар хороо, Аялал жуулчлалын холбоо зэрэг иргэний нийгмийн байгууллагуудтай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Засаг даргын нөөц сангийн 20 сая төгрөгийн санхүүжилтээр 10000 ш аялал жуулчлалын нэгдсэн брошюр хэвлүүлж аймгийн 100 жилийн ойн баяр наадмын үеэр жуулчдад тараах, зочдын гэрт байрлуулж сурталчилж ажилласан.	100	

3.1. "Цахим Монгол" төрийн шуурхай

87	үйлчилгээ	Иргэдэд хүргэх төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлэх	2023 он	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь		100%	100%	30.0	ОНХС	30.00	АЗДТГ-ын ТЗУХ	СЗДТГ	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын харьяа завхан аймаг дахь төрийн цахим үйлчилгээний хэлтэс шинээр байгуулагдаж операторын горим болон киоск машин, утасны аппликейшнаар үйлчилгээ хүргэх цэгүүдийн тоог нэмэгдүүлж, цахим үйлчилгээний талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлах, танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан. "Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх зорилгоор Улиастай,Тосонцэнгэл сумдад ОНТ,ОНХС-ын санхүүжилтээр "Хурдан" цэгийг байгуулж, Улсын бүртгэлийн хэлтэс, ГХБХБГ-аар киоск машинаар болон Баруун бүсийн худалдааны төв, Нэгдсэн эмнэлэг, Шуудан үйлчилгээний газар, 24 сумын ЗДТГ-ын оператороор давхардсан тоогоор 15000 иргэдэд цахим үйлчилгээ үзүүлсэн.	100
88		Түүхт ой тохиож буй сум, байгууллагын ой угтсан бүтээлч ажилд дэмжлэг үзүүлэх	2023 он	Дэмжлэг үзүүлсэн сумын тоо, нэрс	Тэлмэн, Идэр, Эрдэнэх айрхан, Цагаан чулуут, Алдархан, Жавхлант цогцолбор сургууль	Тосонцэнгэл, Нөмрөг, Их-Уул, Завханмандал, Цагаанчулуут, ЧЭЛСургууль	50.0	ОНХС	80.00	АЗДТГ-ын ТЗУХ	СЗДТГ	Түүхт ой тохиож буй сум, байгууллагын ой угтсан бүтээлч ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2023 онд түүхт ойгоо тэмдэглэсэн Тосонцэнгэл, Нөмрөг, Их-Уул, Завханмандал сумууд болон Улиастай сумын 1 дүгээр цэцэрлэг, Тэс сумын цэцэрлэг, Цагаанчулуут сумын ЕБС, Улиастай сумын ЧЭЛСургуульд орон нутгийн төсвөөс 80.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	100	
89		Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаадын төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтыг орон нутагт татах	2023 он	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь		100%	100%	30.0	ОНТ	30.00	АЗДТГ-ын ТЗУХ	Төрийн байгууллага уд	Аймгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр сайдтай байгуулсан гэрээ болон хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Завхан аймаг болон Оросын Холбооны Улсын Бүгд Найрамдах Тува Улсын засгийн газрын хооронд "Худалдаа, эдийн засаг, хөдөө аж ахуй, техник, шинжлэх ухаан, боловсрол, соёлын салбар"-ын хамтын үйл ажиллагааны тухай гэрээ, "Ойг хортон шавьжнаас хамгаалах, Завхан аймгийн (Монгол Улс) болон Бүгд Найрамдах Тува Улсын Эрзин хошууны (Оросын Холбооны Улс) хилийн бус нутагт ойн хортон өвчлөл, ойн түймрээс хамгаалах талаар хамтран ажиллах тухай гэрээний төслүүдийг боловсруулж, аймгийн Засаг даргын 2023 оны 1/790 дугаартай албан бичгээр Гадаад харилцааны яаманд хүргүүлж, хянуулан гэрээ байгуулах зөвшөөрлийг Гадаад харилцааны яамны 2023 оны 09/5730 дугаартай албан бичгээр авч, холбогдох арга хэмжээг авч ажилласан.	90

90		"Аз жаргалтай ажлын байр" арга хэмжээг хэрэгжүүлэх	2023 он	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь	100%	100%	30.0	ОНХС	29.96	АЗДТГ-ын ТЗУХ	Төрийн байгууллагууд	"Аз жаргалтай ажлын байр" арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар ЗДТГ-ын даргаар ахлуулан ажиллуулж, бүх шатны төрийн байгууллагууд хэрэгжилтийг хангаж, төрийн албан хаагчдыг сургаж дадлаажуулах, ажлын байрны ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад чиглэсэн ажлуудыг ээлж дараатайгаар зохион байгуулж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд ажлын орчин нөхцөлийг сайн бүрдүүлэх, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор зөөврийн болон суурин компьютер, принтерээр хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажлын байрны засвар тохижилтыг хийсэн. 2023 онд төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэвийн нэмэгдлийг томилох эрх бүхий албан хаагчдын саналыг үндэслэн зохих журмын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар олгож, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу урамшуулал олгон ажиллаж байна. Мөн төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үндэслэн үр чадварын нэмэгдлийг тогтмол олгож байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу тайлант онд 6 албан хаагчид орон сууцны нөхцлийг сайжруулахад зориулж, тус бүр 6,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээ.	100
91	3.2. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгаж, төрийн чиг үүргийн уялдааг ханган, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгоно.	Аймаг, сумын ОНХС-гийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	2023 он	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь	100%	100%	3.0	ОНХС	0.00	АЗДТГ-ын ХШҮХ	СЗДТГ	Аймгийн Засаг даргын 2023 оны 5 сарын 23-ны өдрийн А/206 тоот захирамж гарч сумдын ОНХС-ын хөрөнгөөр хийгдсэн ажлуудыг газар дээр нь үзэж тайлагналттай тулгах, үйл ажиллагаанд хяналт шинжилгээ-үнэлгээ хийх, зөвлөн туслах, ажлууд хийгдэж байна.	90
92		Бодлогын баримт бичгийн үнэлгээнд иргэдийн оролцоог хангах	2023 он	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь	100%	100%	4.0	ОНТ		АЗДТГ-ын ХШҮХ	СЗДТГ	Оюунлаг таны туслагч ТББ-тай хамтран аймгийн бодлогын баримт бичгийн үнэлгээнд иргэдийн оролцоог хангах хөндлөнгийн үнэлгээг хийлгэсэн.	90
93		Улиастай сумын хяналтын постод LPR камер суурилуулах	2023 он	Дугаар илрүүлэгчтэй камер суурилуулсан сумын тоо	1	2	110.0	ОНХС	109.52	АЗДТГ-ын ХЭЗХ	ЦГ	Улиастай сумаас Улаанбаатар хот руу гарах чиглэлд буюу Мөрөн Улиастай чиглэлийн А1102 дугаартай хатуу хучилттай авто замд улсын дугаар илрүүлэгч дундаж хурдны LPR маркийн хяналтын камер суурилуулах тендерийг зарлан "Оргил дельта трейд" ХХК шалгарч, камерын угсралтыг хийж гүйцэтгэн Их-Уул, Улиастай сумдын хяналтын цэгт зөрчил илрүүлэгч бүхий хяналтын камер суурилуулсан хүлээлгэн өгсөн.	100
94		Цагдаагийн газарт "Теле камер"-ын зориулалтын лед дэлгэц авах /энэ заалт аймгийн ИТХ-ын 80 дугаар тогтоолоор нэмж батлагдсан/	2023 он	Дэлгэцийн тоо	1	2	19.0	ОНТ1	19.00	АЗДТГ-ын ХБТХОХ	ЦГ	Тусгай зориулалтын 65 инчийн GL маркийн ULTRA HD 4-н ширхэг дэлгэцийг авч Улиастай сумын гудамж талбайн хяналтын камертай холбож үйл ажиллагаандаа ашиглаж байна. 2023 оны 11-р сарын 10 байдлаар Теле камерын хяналтаар 65-н зөрчил, 4 гэмт хэргийг илрүүлэн ажилласан байна.	100
95	3.3. Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.	Хэв журам аюулгүй байдал хангах тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нийлүүлэх	2023 он	Нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж	0	Өргөн зурвасын хамгаалалтын хайс 300 ш, хурд хэмжигч 2, Энгэрийн камер, түмбэ	70.0	ОНХС	70.00	АЗДТГ-ын ХЭЗХ	ЦГ	Нийтийн хэв журмыг хамгаалах иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор цагдаагийн албан хаагчдын ашиглах тоног төхөөрөмжийг шинэчилж, энгэрийн камер-30ш, согтуурал тандагч-10ш, торгуулийн багаж-8ш, хурд хэмжигч-1ш, хамгаалалтын түмбэ-50 ширхэг, хамгаалалтын хайс-150 ширхэг согтуурлын зэрэг хэмжигч багаж-8ш зэрэг тоног төхөөрөмжийг хүлээн авч, үйл ажиллагаандаа ашиглаж байна.	100

96		Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх	2023 он	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь									Энэ онд НҮБ-аас Авлигын эсрэг конвенц батлагдсаны 20 жилийн ойг тохиолдуулан "Дэлхий нийтээрээ авлигын эсрэг нэгдье" уриалгыг дэвшүүлэн, тус конвенцод нэгдсэн улс орон бүр зорилтот үйл ажиллагаа хэрэгжүүлж байна. Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарласны дагуу олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиг үүргийнхээ хүрээнд авлигын эсрэг НЭГДЬЕ үндэсний хэмжээний нөлөөллийн аяныг эхлүүлж, Завхан аймаг уг аянд нэгдэн Улиастай сумын орох гарах самбар, мөн Улиастай сумын "Чигэстэй голын гүүр"-ний хэсэгт "Нэгдье" аяны сурталчилгааны самбарыг байрлуулсан. 2023 оны авлигын эсрэг төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан ажиллаж байна. "Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг хууль тогтоомж" сэдэвт сургалтыг сумын Засаг дарга, Тамгын газрын дарга нар, төрийн захиргааны албан хаагчдад зохион байгуулж, нийт 500 гаруй албан хаагч хамрагдлаа.	100
97	3.4. Хараат бус шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлнэ.	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх төвийн үйл ажиллагааг дэмжих	2023 он	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь									Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төв нь энэ онд гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогч 51 хүн (насанд хүрсэн 26, хүүхэд 25)-ийг 1-10 хоногийн хугацаатайгаар 184 хоног хамгаалах байранд байрлуулан, аюулгүй байдлыг хангаж, хохирогчдод шаардлагатай багц үйлчилгээнүүдийг төлөвлөн үзүүлсэн. Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр хохирогчдод сэтгэлзүйн зөвлөгөө өгөх орчинг бүрдүүлэн, амьдрах ухааны сургалтад хамруулж, 4 улирлын хүлэмж байгуулан өргөст хэмх, улаан лооль тариалж, хүлэмжний дотор хэсэгт сэтгэл зүйн булан байгуулж, утсаар 12 иргэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажилласан. Нэг цэгийн үйлчилгээний төвийн эрх зүйчийг "И тусламжийн арга зүй", "Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, насанд хүрэгчидтэй ажиллах кейс үйлчилгээ" зэрэг 10 удаагийн сургалт, хэлэлцүүлэгт хамруулж чадавхжуулсан байна. Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэй "Гүүд нэйборс" олон улсын төрийн бус байгууллагаас зохион байгуулсан "Сэтгэл зүйн зөвлөгөөний цогц сургалт"-нд Нэг цэгийн үйлчилгээний төвийг хамруулан 2,1 сая төгрөгийн сэтгэл зүйн үйлчилгээний цогц хөтөлбөрийн багц хэрэглэгдэхүүнээр хангасан.	100
98		Кибер аюулгүй байдлын хяналтыг сайжруулж, гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх	2023 он	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь	2021 оны төлөвлөгөөний биелэлт 70%-д хүрсэн.	Төлөвлөгөөний тухайн жилийн биелэлт 95%-д хүрсэн байна.							Завхан аймаг дахь Салбар зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөлийн даргаар батлуулан ажиллаж байна. /нууц/ Аймгийн Засаг даргын захирамжаар Кибер аюулгүй байдлын хяналтыг сайжруулж, гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулсан.	100
99		Гал унтраах техникийн олон төрөлт спортын баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг Тосонцэнгэл суманд зохион байгуулах	2023 он	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь									Гал унтраах олон төрөлт спортын "Мөнгөн дуулга" клубын аварга шалгаруулах тэмцээн Улиастай хотод 06 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд баруун таван /Ховд, Завхан, Баян-Өлгий, Увс, Говь-Алтай/ аймгийн 50 гаруй тамирчид оролцсон.	100

100		Хяналтын тоонд багтаан хугацаат албаны цэрэг татлагыг 2 удаа зохион байгуулах	2023 он	Цэргийн албан хаагчдын тоо	700	700-аас доошгүй	12.0	ОНТ	18.00	АЗДТГ-ын ЦШ	24 сумын Засаг дарга	Аймгийн Засаг даргын 2023 оны А/120, А/364 дугаар захирамжаар томилогдсон I, II ээлжийн цэрэг татлагын комисс 24 суманд ажиллаж цэрэг татлагын ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулсан. 18-25 насны цэргийн насны залуучуудыг хууль, журамд заасны дагуу цэргийн албанд тэнцүүлэн татаж хяналтын тоог биелүүлсэн.	100
101		Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж буй бүрэлдэхүүний сургалт дадлагыг зохион байгуулах	2023 он	Сургалтад хамрагчдын тоо	80	80	8.0	ЦМТ	9.70	АЗДТГ-ын ЦШ	25 сумын ЗДТГ	Засгийн газрын тогтоолоор тогтоосон хяналтын тооны дагуу 80 иргэн цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байна. Аймгийн Засаг даргын 2023 оны А/220 дугаар захирамжаар цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж буй иргэдэд Батлан хамгаалахын сайдын 2018 оны А/211 дүгээр тушаалаар батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу "Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл" сургалтыг 2023 оны 5 дугаар сарын 29-нөөс 6 дугаар сарын 21-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулав.	100
102		Аймгийн аварга шалгаруулах Дөл тэмцээн зохион байгуулах	2023 он	Оролцогчдын тоо	117	377	8.0	ЦМТ	8.10	АЗДТГ-ын ЦШ	БШУГ, ГБХЗХГ, Зэвсэгт хүчний 325 дугаар анги, ОБГ	Аймгийн Засаг даргын 2023 оны А/193 дугаар захирамжаар Завхан аймаг үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг утгаж, аймгийн Засаг даргын ивээл дор цэрэг спортын "Дөл-2023" аймгийн аварга шалгаруулах цогцолбор тэмцээнийг амжилттай зохион байгуулж, 6 сумын 10 сургуулийн баг тамирчид оролцлоо.	100
103	3.5. Батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, мэргэжлийн чадварлаг боловсон хүчнийг бэлтгэнэ.	Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний дэд төлөвлөгөөг хэрэгжүүлэх	2023 он	Хамрагдах хүүхэд залуучуудын тоо	1500	2000-с доошгүй	10.0	ЦМТ	9.70	АЗДТГ-ын ЦШ	АЗДТГ-ын НБХ, БШУГ	Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний дэд төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЕБС-ийн сурагчдыг цэрэг эх оронч үзэлтэй бие бялдар сэтгэл зүйн өв тэгш хүмүүжилтэй иргэн болгон төлөвшүүлэх ажлыг аймгийн ЕБС-ийн ахлах ангийн сурагчдыг хамруулан 2 үе шаттайгаар "Дөл" спорт цогцолбор тэмцээнийг зохион байгууллаа. "Дөл" спорт цогцолбор тэмцээний 1 дүгээр шатанд ЕБ-ын 29 сургуулийн ахлах ангийн 450 сурагч, 2 дугаар шатны тэмцээнд шалгарсан 13 багийн 180 гаруй сурагчид амжилттай оролцож аваргуудаа шалгаруулж шагнаж урамшуулав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Бидний бахархал" төслийн хүрээнд "Монгол хурандаа нийгэмлэг"-ээс 21 аймаг, 9 дүүрэгт хэрэгжүүлж буй хүүхэд залууст эх оронч үзэл төлөвшүүлэх цэрэг эх орны тухай мэдээллийг түгээх, сурталчлан таниулах ажлыг төлөвлөгөөний дагуу 2023 оны 09 дүгээр сарын 17, 18-ны өдрүүдэд зохион байгуулан ахлах ангийн сурагчид болон цэргийн байгууллагынхан, чөлөөнд гарсан ахмадууд зэрэг нийт 400 гаруй хүн оролцов. ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын тэсвэр хатуужил, авхаалж самбааг сорих, хүнлэг энэрэнгүй иргэн болгох, аюулт үзэгдэл, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, өөртөө болон бусдад анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэхэд сургаж дадлагуулах зорилготой "Өсвөрийн аврагч-2023" аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг БШУГ, ОБГ-тай хамтран зохион байгуулсан. Залуучуудыг цэрэг татлагад идэвхтэй хамрагдах чиглэлээр цэргийн штабтай хамтран видео танилцуулга, уриалга бэлтгэн нийтэлж, 1600 залуучуудад уриалгаа хүргэж ажилласан байна.	100
104		Хугацаат цэргийн алба хааж буй дайчдын цэргийн албаны үйл ажиллагаатай танилцах, тэдний ар гэрт нь дэмжлэг, тусалцаа үзүүлэх	2023 он	Дэмжлэг үзүүлэх албан хаагчдын тоо	250	500	20.0	ЦМТ	24.00	АЗДТГ-ын ЦШ	СЗДТГ	Аймгийн Засаг даргын 2023 оны А/58 дугаар захирамжаар хугацаат цэргийн алба хааж буй дайчдын цэргийн албаны үйл ажиллагаатай танилцах, уулзалт арга хэмжээг Зэвсэгт хүчний 339, 340, Хилийн 0311 дүгээр ангид зохион байгуулан ажиллав. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аймгийн Засаг даргын орлогч, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга болон албаны бусад хүмүүс оролцож, аймаг орон нутгийн мэдээ, мэдээлэл, мэндчилгээ, захидал, Засаг даргын гарын бэлгийг гардуулан өгч, урлаг соёлын арга хэмжээгээр үйлчиллээ.	100
ГУРАВДУГААР БҮЛГИЙН ДУНДАЖ													98.70

4. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО													
105		"Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд тарьц суулгац авах	2023 он	Дэмжлэгээр олгосон тарьц суулгацын тоо, ширхэг	4600	8000-аас доошгүй	40.0	ОНХС	40.00	АЗДТГ-ын ХБТХОХ	БОАЖГ, СДОА,СЗД ТГ, ОМБ	Хавчгийн ногоон мод ХХК гүйцэтгэгчээр шалгарч 2000 бургас, 3000 хайлаас, 2000 голт бор, 500 шар хуайс, 400 далан хальс, 200 үхрийн нүд нийт 8100 ширхэг тарьц, суулгац нийлүүлсэн. Тарьц, суулгацыг 23 сум, Улиастай сумын 6 багт хуваарилан айл өрх,албан байгууллагууд эзэмшлийн газартаа тарьсан.	100
106		"Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд Баянтэс суманд мод тарьж, цэцэрлэгт хүрээлэн байгуулах	2023 он	Үйл ажиллагааны гүйцэтгэлээр	0	100%	50.0	ОНХС	50.00	АЗДТГ-ын ХБТХОХ	БОАЖГ, СДОА,СЗД ТГ, ОМБ	"Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд Баянтэс суманд мод тарьж, цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг "Жак Тэх" ХХК хийж гүйцэтгэсэн. Шинээр 20 ширхэг гэрэлтүүлэг хийж, хуучин гэрэлтүүлгийн шонг будаж шинэчилсэн. Үүнд 100 ватт-ын (philips chip) гэрэлтүүлгийг 2*16 агаарын сип кабелиар тэжээж, бүрэн тоноглон.	100
107		Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хөтөлбөрийн хүрээнд Алдархаан, Баянтэс, Идэр, Тэс, Улиастай, Цагаанхайрхан сумдад татмын ойжуулалт, хашаажуулалт хийх /энэ хэсэгт ОНХС 176.6 төгрөгөөр ТХ 412.1 сая төгрөгөөр нэмэгдэж аймгийн ИТХ-ын 69 дүгээр тогтоолоор батлагдсан/	2023 он	Талбайн хэмжээ, га	5	65	320.6-ОНХС, 748.1 ТХ	ОНХС, ТХ	0.00	АЗДТГ-ын ХБТХОХ	БОАЖГ, АДАПТ төсөл, СЗДТГ	Алдархаан суманд 30 га талбайд татмын ойжуулалт, 15 га талбайд татмын ойн цэвэрлэгээ хийхээр "Отгон баян уул" ХХК, Идэр суманд 20 га талбайд татмын ойжуулалт хийхээр "Хавчгийн ногоон мод" ХХК, Баянтэс суманд 15 га талбайд татмын ойжуулалт, 10 га талбайд татмын ойн цэвэрлэгээ хийхээр "Отгон баян уул" ХХК, Цагаанхайрхан суманд 5 га талбайд татмын ойжуулалт, 10 га талбайд татмын ойн цэвэрлэгээ хийхээр "Шилмүүст хангай" ХХК, Улиастай суманд 10 га талбайд "Мөнх ногоон ой" ХХК тус тус шалгарч нийт 80 га талбайд татмын ойжуулалт, 35 га талбайд татмын ойн цэвэрлэгээ хийхээр шалгарч ажлыг гүйцэтгэж байна. Тэс суманд хийгдэх татмын ойжуулалтын ажлыг шууд гэрээ байгуулах зөвлөмж хүргэгдсэн.	90
108	4.1. Байгалийн нөөцийг хамгаалж, нөхөн сэргээж, зохистой ашиглалтыг бий болгоно.	Арчны нөөц, тархалтын судалгааг дуусгах	2023 он	Хамрагдах газар нутаг	2022 онд Хангайн нурууны салбар уулс, Богдын гол	Төмөртэйн гол, Ширээгийн гол дагуу	10.0	ОНХС	10.00	АЗДТГ-ын ХБТХОХ	БОАЖГ, Мэргэжлийн байгууллага	Алдархаан, Цагаанхайрхан сумын арчны нөөц, тархалтын судалгааг "Отгон бор хавцал" төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан хийж гүйцэтгэсэн. Тус судалгааны ажлыг 2 үе шаттай хийж гүйцэтгэн 91 цэгээс дээж авч зүйлийн бүрдэл, нөөцийн судалгааг хийсэн. Нийт 112.128 км2 талбайд арц ургаж байна. Алдархаан суманд 18.4 тн, Цагаанхайрхан суманд 21.05 тн арчны нөөцтэй бөгөөд эдгээр нөөцийн 10 хувийг ашиглах боломжтой гэж дүгнэлт гаргаж арчны нөөц, тархалтын судалгааг дуусгасан.	100
109		Отгонтэнгэр хайрханы өвөрт нийтийн 00 барих /энэ заалт аймгийн ИТХ-ын 69 дүгээр тогтоолоор нэмж батлагдсан/	2023 он	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь	0%	100%	21.0	ОНТ1	21.00	АЗДТГ-ын ХБТХОХ	БОАЖГ, СГЗ, ОТУТГХЗ, Мэргэжлийн байгууллага	Отгонтэнгэрийн ДЦГ-ын Отгонтэнгэр уулын өвөр хэсэгт 00 барих ажлыг Отгон суманд эрх шилжүүлж, "ЦЭН ЭКО ТӨГӨЛ" ХХК нь гэрээ байгуулан ажиллаж, гүйцэтгэлийг хамгаалалтын захиргааны ажлын хэсэг хүлээн авч ажилласан.	100
110		Улаагчны хар нуурын загасны нөөцийг тогтоох	2023 он	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь	0	100%	25.0	БХНСАХ 3		АЗДТГ-ын ХБТХОХ	БОАЖГ, СГЗ, ОТУТГХЗ, Мэргэжлийн байгууллага	Улаагчны хар нуурын загасны нөөцийг тогтоох ажлын гүйцэтгэгчээр "Биологийн хүрээлэн" шалгарсан бөгөөд техникийн тодорхойлолтын дагуу 7 дугаар сард нуурын загасны нөөц тогтоох, нуурын ёроолын сээр нуруугүйтан амьтан болон идэш тэжээлийн судалгаа хийсэн. 10-11 сард загасны үржил, нөхөн төлжилт болон идэш тэжээлийн нөөцийг тогтоох судалгааг хийж тайланг аймгийн БОАЖГ-т хүлээлгэж өгнө.	70

111		Усан сан бүхий онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг	2023 он	Тэмдэгжүүлсэн цэгийн тоо	44	57	6.5	БХНСАХ 3	6.50	АЗДТГ-ын ХБТХОХ	БОАЖГ, СГЗ,	Улиастай, Алдархаан, Цагаанхайрхан, Эрдэнэхайрхан сумдад Усан сан бүхий онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн тэмдэгжүүлэлтийн 13 ширхэг самбарыг хийж хүлээлгэн өгсөн.	100
112		Гадаргын усны тооллого явуулах	2023 он	Хамрагдах сав газар	3	3	15.0	БХНСАХ 3	10.50	АЗДТГ-ын ХБТХОХ	БОАЖГ, СГЗ, СЗДТГ	Идэр голын сав газрын захиргаа гадаргын усны тооллогыг харьяалагдах Тосонцэнгэл, Идэр, Их-Уул, Тэлмэн сумдад хийж гүйцэтгэсэн. Тус 4 суманд нийтдээ 262 булаг, 139 гол горхи, 4 рашаан, 100 худаг, 2 усны барилга байгууламж, 89 нуур тоологдсон байна. Тооллогын нэгдсэн дүн болон тайланг 12 дугаар сард багтаан холбогдох газруудад хүргүүлэхээр ажилаж байна.	50
113		Усан сан бүхий газрын хамгаалалтын бүсийн дэглэм мөрдүүлэх	2023 он	Хяналт шалгалтын тоо, арилгасан зөрчлийн тоо	6 удаа, 4 зөрчил	2 удаа	3.0	БХНСАХ 3	1.50	АЗДТГ-ын ХБТХОХ	БОАЖГ, СГЗ, СЗДТГ, ААНБ	Хяргас-Нуур Завхан голын сав газрын захиргаа хяналт шалгалт хийх ажлын удирдамж төлөвлөгөөг боловсруулан Улиастай, Сонгино, Нөмрөг, Отгон сумдад хяналт шалгалтын ажлыг хийж байна. Тайланг 12 сард хүлээлгэж өгнө.	70
114		Хаягдал уснаас дээж авч, шинжлүүлэн холбогдох арга хэмжээ авах	2023 он	Хаягдал усны дээжийн тоо	0	10	2.0	БХНСАХ 3	2.00	АЗДТГ-ын ХБТХОХ	БОАЖГ, СГЗ,	Хяргас-Нуур Завхан голын сав газрын захиргаа Улиастай, Цагаанхайрхан, Сонгино, Нөмрөг сумдад нийт 14 ААНБ-аас хаягдал уснаас дээж авч шинжлүүлсэн.	90
115		Хөрсний доройтол, цөлжилтийн төлөв байдал, тархалтын судалгаа хийх	2023 он	Хамрагдах сум	Анхан шатны судалгаа 2020 онд хийгдсэн	Эрдэнэхайрхан, Дөрвөлжин, Ургамал сумд	25.0	БХНСАХ 3	25.00	АЗДТГ-ын ХБТХОХ	УЦУОШТ, ХААИС, ШУТИС, СЗДТГ	"Гарааны ногоон дэлхийн чанар" ХХК гүйцэтгэгчээр шалгарч Дөрвөлжин, Ургамал, Эрдэнэхайрхан, Завханмандал, Сантмаргаз сумдад хөрсний доройтол, цөлжилтийн төлөв байдлын судалгааны ажил хийгдэж байна.	70
116		Тэлмэн суманд хог хаягдал тээвэрлэх автомашин авах	2023 он	Авто машины тоо	0	1	80.0	ОНХС	80.00	АЗДТГ-ын ХБТХОХ	Тэлмэн СЗДТГ	Гүйцэтгэгчээр "Боврой ХХК" шалгарч хог хаягдал тээвэрлэх авто машиныг Тэлмэн сумын Засаг даргын Тамгын газарт хүлээлгэж өгсөн.	100
117	4.2. Хүрээлэн буй орчны бохирдол,	Улиастай сумын хот тохижилт, үйлчилгээний албанд хогны машин авах	2023 он	Автомашин тоо	1	2	80.0	ОНХС	80.00	АЗДТГ-ын ХБТХОХ	СЗДТГ	Улиастай сумын Хот тохижилт үйлчилгээний албанд 2013 онд үйлдвэрлэгдсэн, 2022 оны 8 сард орж ирсэн 5тн хүчин чадалтай, ачааны өөрөө буулгагчтай, чанга яригч болон байршил тогтоогчтой HUNDAI TRUCK маркийн машиныг нийлүүлж, комисс ажиллаж хүлээн авсан. Одоо ХТҮА-нд ашиглагдаж байна.	100
118	доройтлыг бууруулж уур амьсгалын өөрчлөлтөд	Түдэвтэй суманд хог хаягдал тээвэрлэх автомашин авах	2023 он	Автомашин тоо	0	1	50.0	ОНХС	49.70	АЗДТГ-ын ХБТХОХ	Түдэвтэй СЗДТГ	Гүйцэтгэгчээр "Отгомюр ХХК" шалгарч Түдэвтэй сумын Засаг даргын Тамгын газарт хог хаягдал тээвэрлэх авто машиныг хүлээлгэж өгсөн.	100
119	дасан зохицох, даван туулах чадавхыг бэхжүүлнэ.	Улиастай сумын нийтийн эзэмшлийн газар болон орон сууцны гадаа хогийн сав байрлуулах /энэ заалт аймгийн ИТХ-ын 69 дүгээр тогтоолоор нэмж батлагдсан/	2023 он	Гүйцэтгэлийн хувь	0%	100%	37.0	ОНТ1	37.00	АЗДТГ-ын ХБТХОХ	БОАЖГ, Улиастай СЗДТГ	"Эко Энержи Ресурс" ХХК гүйцэтгэж Улиастай сум руу орох, гарах чиглэлийн 4 пост дээр 3х2х2 харьцаатай зөөврийн 4 ширхэг, Орон сууцнуудын гадна 3х2,6х3 харьцаатай шивлэрэн рамтай, торон ханатай 6 ширхэг, төв гудамж дагуу 1х0,4х0,8 харьцаатай бороо, усны хамгаалалттай 22 ширхэг, нийт 32 ширхэг хогийн савнуудыг байршуулж, комисс ажиллаж хүлээн авсан.	100
120		Аймгийн нутаг дэвсгэрт хур тунадас нэмэгдүүлж, гангийн эрсдэлийг бууруулах	2023 он	Зун, зуншлага, хувь	60%	75%	10.0	БХНСАХ 3	10.00	АЗДТГ-ын ХБТХОХ	УЦУОШТ, БОАЖГ, СЗДТГ	Гангийн эрсдэлийг бууруулах зорилгоор 2023 онд 6 удаа үүлэнд нөлөөлж, хур тунадас нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулсан. Мөн хуурайшилтын зэргийг 04 сарын 01-ээс 05 сарын 01 хүртэлх хугацаанд 24 сумаар авч 37 удаагийн нэн эрсдэлтэй, аюултай үеийн мэдээг гаргаж иргэдийн гар утсанд мессежээр сэрэмжлүүлэг өгч ажилласан.	100

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛГИЙН ДУНДАЖ											90	
5. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО												
121	Засаг даргын Тамгын газрын барилга /Завхан, Түдэвтэй сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	100%	100%	274.2	УТ	274.10	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, СЗДТГ	Түдэвтэй сумын ЗДТГ-ын барилга угсралтын ажлыг 2022 онд хийж дууссан. УИХ-ын 88-р тогтоолын дагуу 2023 онд улсын төсөвт үнийн өсөлтийн нэмэгдэл санхүүжилт батлагдаж, санхүүжилтээ авсан. Угсралтын ажил 100% хийсэн.	100
122	Засаг даргын Тамгын газрын барилга /Завхан, Шилүүстэй сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	80%	100%	218.5	УТ	218.50	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, СЗДТГ	УИХ-ын 88-р тогтоолын дагуу 2023 онд улсын төсөвт үнийн өсөлтийн нэмэгдэл санхүүжилт батлагдсан. 2023 оны ажил эхэлж, гадна фассад хийж, халаалт оруулж дотор засал хийгдэж байна.	90
123	Засаг даргын Тамгын газрын барилга /Завхан, Ургамал сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	100%	100%	262.7	УТ	262.70	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, СЗДТГ	2022 онд ЗДТГ-ын барилгыг барьж дууссан. УИХ-ын 88-р тогтоолын дагуу 2023 онд улсын төсөвт үнийн өсөлтийн нэмэгдэл санхүүжилт батлагдаж гүйцэтгэгч санхүүжилт авсан. Угсралтын ажил 100% хийсэн.	100
124	Яруугийн хүрээнд мод тарьж, цэцэрлэгт хүрээлэн байгуулах төсөл /Завхан, Алдархаан сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	30%	100%	212.5	УТ	212.50	АЗДТГ-ын ХБТХОХ	БОАЖГ	"Говийн Улиас" ХХК гүйцэтгэгчээр шалгарч, Алдархаан сумын Яруугийн хүрээнд туурийг хамгаалж 34 га талбайд хамгаалалтын хашаа барьсан. Хамгаалалтын зурваст 3360 ширхэг мод тарихаас 5308 ширхэг мод тарьж амьдралт 84 хувьтай ургаж байна. Гүний худаг өрөмдөж, барилгын ажлыг гүйцэтгэн 25 тоннын ус нөөцлөх сав суурилуулсан.Тарьсан модонд 1500 метр дуслын усалгааны систем суурилуулж, хэвийн ажиллаж байна.	100
125	Хог хаягдал шатаах зориулалтын дунд оврын зуух /Завхан, Отгон, Эрдэнэхайрхан, Улиастай, Тосонцэнгэл, Дөрвөлжин, Цагаанхайрхан, Тэс, Сонгино сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	30%	100%	1,804.2	УТ	1804.20	АЗДТГ-ын ХБТХОХ	БОАЖГ	Гүйцэтгэгчийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам шалгаруулж, "Цэцүүх трейд" ХХК-тай 2022-2023 онд хог хаягдал шатаах дунд оврын зуух нийлүүлэх гэрээ байгуулж, 2023 оны 06 сард ажлын хэсэг тоног төхөөрөмжийг хүлээж авсан. 9 дүгээр сарын 13-14-ны өдрүүдэд 8 сумын хог хаягдал шатаах зуухыг ажиллуулах ажилчдад тоног төхөөрөмжийн болон аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтыг зохион байгуулж ажилласан.	100
126	Тэлмэн нуурын аялал жуулчлалын бүсийн зураг төсөв /Завхан, Тэлмэн сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	30%	100%	308.0	УТ	308.00	АЗДТГ-ын ХБТХОХ	БОАЖГ	Тэлмэн нуурын аялал жуулчлалын зураг төсвийг Байгаль орчин аялал жуулчлалын яамны захиалгаар "Сонголт дизайн" ХХК гүйцэтгэж, магадлалаар оруулж хүлээлгэн өгсөн. Орон нутгаас шаардагдах бүх ажлыг хийж, зөвшилцсөн. Ажлын гүйцэтгэл 100% хийсэн.	100
127	Сумын төвийн шинэчлэл /Завхан, Алдархаан сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	90%	100%	49.3	УТ	49.30	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, СЗДТГ	Алдархаан сумд иж бүрэн инженерийн төвлөрсөн шугам сүлжээ хийж, цэвэр усны нөөцийн сав, 50 м3 цэвэрлэх байгууламж, сумын төвийн доторх 1.6 км хатуу хучилттай авто зам, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж хийсэн. Мөн "Бурхант хясаат" ХХК өөрийн хөрөнгөөр Цэвэр усны худаг хүртэлх ЦДАШ-ын ажлыг хийсэн.	100
128	Сумын төвийн шинэчлэл /Завхан, Отгон сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	90%	100%	431.4	УТ	431.40	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, СЗДТГ	Отгон сумын төвийн шинэчлэл төсөл нь иж бүрэн инженерийн төвлөрсөн шугам сүлжээ, халаалтын зуух, цэвэр усны сав, 50 м3 бохир ус цэвэрлэх байгууламж зэргийг хийж ашиглалтад оруулсан.	100
129	Аймгийн хэмжээнд шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн зураг төсөв /Завхан/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	30%	100%	458.1	УТ	458.10	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ	Барилга, хот байгуулалтын яаманд тендер зарлагдаж гүйцэтгэгчээр "Эрхэс констракшн" ХХК шалгарч нийт 12 барилга байгууламжийн зураг төслийн ажил хийгдэж, барилгын хөгжлийн төвийн магадлалаар хяналт хийлгэж байна. Ажлын гүйцэтгэл 100% хийсэн.	100

130	Жавхлант цогцолбор сургуулийн 2 дугаар байрны барилга /Завхан, Улиастай сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	90%	100%	387.8	УТ	387.50	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, БШУГ	Жавхлант цогцолбор сургуулийн 640 хүүхдийн хичээлийн байрны барилгыг 2021 оны 12 сард улсын комисс ажиллаж үүрэг даалгаварын биелэлтээр хүлээн авсан. Спорт заалны барилгын ажлын дутууг 2022.06.03-наас 2022.08.31-ний өдөр дуусгахаар нэмэлт гэрээг УИХ-ын 88-р тогтоолын дагуу хийсэн. Гүйцэтгэгч байгууллагад ажлыг эхлүүлэх талаар 2023 оны 06 сарын 02-ны өдрийн албан тоот хүргүүлсэн. Спорт заалны барилгын бетон шалны цуггалт, дотор заслын ажил дутуу хийгдэж, барилгыг ашиглалтад хүлээж аваагүй байна. Ажлын гүйцэтгэл 90% хийсэн.	90
131	Сургуулийн барилга, 240 суудал /Завхан, Эрдэнэхайрхан сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	70%	100%	968.1	УТ	968.10	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, БШУГ	2023 оны 5 дугаар сарын байдлаар газар шороо суурь, 1 ба 2 давхрын каркас, гадна дотор ханын өрлөг, шавар, хавтгай дээвэр, цонх угсрах ажлууд хийгдсэн. Барилгын зураг төсөв боловсруулах ажил 2020 онд хийгдэж барилгын хөгжлийн төвийн магадлалаар 2801.8 сая төгрөгөөр хянагдаж баталгаажсан боловч улсын төсөвт 2528.5 сая төгрөгөөр санхүүжилт батлагдсан. Мөн 2022 онд 1428.5 сая төгрөг улсын төсөвт батлагдсан боловч барилга угсралтын ажил удааширч ашиглалтад ороогүйн улмаас 810 сая төгрөгийн санхүүжилт татагдсан. 2023 онд санхүүжилт байхгүй, ажлын гүйцэтгэл 70%-тай ажил зогссон.	70
132	Цэцэрлэгийн барилга /Завхан, Улиастай сум, 1 дүгээр цэцэрлэг/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	100%	100%	440.7	УТ	440.70	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, БШУГ	Улиастай сумын 1 дүгээр цэцэрлэгийн барилгыг 2022 онд тус дуусгаж ашиглалтад өгсөн. УИХ-ын 88-р тогтоолын дагуу 2023 онд улсын төсөвт үнийн өсөлтийн нэмэгдэл санхүүжилт батлагдаж гүйцэтгэгч санхүүжилтээ авсан. Угсралтын ажил 100% хийгдсэн.	100
133	Цэцэрлэгийн барилга /Завхан, Цэцэн-Уул сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	100%	100%	364.5	УТ	364.50	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, БШУГ	Цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг 2022 онд дуусгаж ашиглалтад оруулсан. УИХ-ын 88-р тогтоолын дагуу 2023 онд улсын төсөвт үнийн өсөлтийн нэмэгдэл санхүүжилт батлагдаж гүйцэтгэгч санхүүжилтээ авсан. Угсралтын ажил 100% хийгдсэн.	100
134	Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Завхан, Идэр сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	100%	100%	1,074.7	УТ	1074.70	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, БШУГ	Барилгын ажил 5-р сарын 01-ний өдөр эхэлсэн. Цонх, дотор цахилгаан, сантехникийн угсралтын ажил хийгдэж байна. УИХ-ын 88-р тогтоолын үнийн өсөлтийн гэрээ хийгдсэн. Барилгын талбайд материал татан авалт хийж, ажил эхэлсэн боловч гүйцэтгэл 70%-тай, технологийн зогсолт хийсэн.	70
135	Цэцэрлэгийн барилга /Завхан, Улиастай сум, 9 дүгээр цэцэрлэг/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	100%	100%	536.4	УТ	536.40	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, БШУГ	Цэцэрлэгийн барилга угсралтын ажил дуусаж, ашиглалтад хүлээлгэн өгсөн. УИХ-ын 88-р тогтоолын дагуу 2023 онд улсын төсөвт үнийн өсөлтийн нэмэгдэл санхүүжилт батлагдаж гүйцэтгэгч санхүүжилтээ авсан. Ажлын гүйцэтгэл 100% хийсэн.	100
136	Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Завхан, Сонгино сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	100%	100%	1,276.7	УТ	1276.70	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, БШУГ	Сургуулийн барилга угсралтын ажлыг "Харганат" ХХК гүйцэтгэж, 2023 оны 5 сарын 12-ны өдөр комисс ажиллаж ашиглалтад хүлээн авсан. Ажлын гүйцэтгэл 100% хийсэн.	100
137	Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Завхан, Тэлмэн сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	70%	100%	809.7	УТ	809.70	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, БШУГ	Гүйцэтгэгч "Тэнгэрийн тэмдэг" ХХК барилга угсралтын ажлыг хийж дууссан. УИХ-ын 88-р тогтоолын дагуу гэрээ хийгдэж, 2023 оны 10 сарын 27-нд комисс ажиллаж, ашиглалтад хүлээн авсан. Барилга угсралтын ажил 100% хийсэн.	100

138	Сургуулийн спорт заалны барилга /Завхан, Цагаанчулуут сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	50%	100%	208.9	УТ	208.90	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, БШУГ	2021 онд барилгын каркас, гадна ханын өрлөг, шавар, цахилгаан сантехникийн монтаж хийгдсэн. Ажил эхэлсэн дээврийн ажлын угсралт гүйцэтгэсэн. 2022 онд гадна дулааны холболт хийж халаалт авч дотор засал, модон шал шахах ажлууд хийгдэж, технологийн зогсолт хийсэн. 2023 оны 4-р сард барилгын ажил эхэлж гадна дотор заслын ажлууд хийгдэж, 7 дугаар сард комисс ажиллаж ашиглалтад оруулсан. УИХ-ын 88-р тогтоолын дагуу гэрээ байгуулж 180.0 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон. Ажлын гүйцэтгэл 100% хийсэн.	100
139	Цэцэрлэгийн барилга /Завхан, Тосонцэнгэл сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	80%	100%	293.9	УТ	182.50	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, БШУГ	Цэцэрлэгийн барилгын гадна, дотор өрлөг, дотор ханын шавар 2021 онд хийгдсэн. 2023 оны 04 сараас хавтгай дээвэр, гадна фасад, дотор сан, цахилгааны ажил эхэлсэн. УИХ-ын 88-р тогтоолын дагуу гэрээ байгуулагдсан. Цэцэрлэг нь гэрээ дулаалж, түлш бэлдээгүй хүйтэрсэн, тус барилгад орохоос өөр аргагүй байсан тул 2023 оны 11 сарын 07-ны өдөр комисс ажиллаж, дутуу ажлуудыг гэрээний дагуу 2024 оны 05 сард багтаан гүйцэтгэхээр ашиглалтад оруулсан. . Ажлын гүйцэтгэл 90% хийсэн.	90
140	Дотуур байрны барилга, 75 ор /Завхан, Асгат сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	60%	100%	263.7	УТ	263.70	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, БШУГ	УИХ-ын 88-р тогтоолын дагуу 2023 онд улсын төсөвт үнийн өсөлтийн нэмэгдэл санхүүжилт батлагдсан. Барилгын ажлыг эхлүүлэх талаар 2023 оны 06-р сарын 02-ны өдрийн 240 тоот албан бичиг хүргүүлсэн. Барилга угсралтын ажил хийгдсэн. Ажлын гүйцэтгэл 70% хийсэн.	70
141	Насан туршийн боловсролын төв, Боловсролын газрын барилга /Завхан, Улиастай сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	80%	100%	467.1	УТ	467.10	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, БШУГ	Насан туршийн боловсролын төв, Боловсролын газрын барилгыг 2022 онд ашиглалтад оруулсан. УИХ-ын 88-р тогтоолын дагуу 2023 онд улсын төсөвт үнийн өсөлтийн нэмэгдэл санхүүжилт батлагдаж гүйцэтгэгч санхүүжилтээ авсан. Ажлын гүйцэтгэл 100% хийсэн.	100
142	Сургуулийн барилга, 640 суудал /Завхан, Улиастай сум, 5 дугаар баг/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	20%	100%	3,152.2	УТ	3152.20	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, БШУГ	Газар шороо, ул бетон цутгах А,Б,В блокийн баганан суурь, суурийн холбоос дам нуруу, цутгамал ханын ажил хийгдэж, суурийн 10 см хөөсөн дулаалга, уур ус тусгаарлагчийн ажлууд гүйцэтгэсэн. 2022 онд 760.0 сая төгрөгөөр нэмэлт санхүүжилт авсан. 2023 оны 5 дугаар сарын 10-аас ажил эхэлж, А,Б,В блокийн дээд үеийн суурийн холбоос дам нурууны хэв хашмал арматурчлал хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 50% хийсэн.	50
143	Сургуулийн спорт заалны барилга /Завхан, Отгон сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	20%	100%	1,550.1	УТ		АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, БШУГ	Нэг маягийн зурагт суурийн холболт хийгдэж магадлагаар баталгаажсан. Барилга барих газар олон жилийн цэвдэг хөрстэй тул барилгын суурийн ажлыг хүйтний улиралд хийх технологийн заавартай 3 дугаар сарын 27-нд барилгын ажил эхэлсэн. Бүх баганан суурийг хийж хар тосон түрхлэг түрхэж булалт хийсэн. Ажил удаашралтай хийсэн тул 2023 оны 1.5 тэрбум төгрөг татагдсан. Ажлын гүйцэтгэл 20% хийсэн.	30
144	Сургуулийн спорт заалны барилга /Завхан, Цагаанхайрхан сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	20%	100%	1,108.6	УТ		АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, БШУГ	Газар шороо суурийн ажил хийгдэж, "Ре констракшн төв"-өөр бетоны бат бэхийг тодорхойлуулсны дараа барилгын ажил эхэлсэн. Суурийн дам нуруу хөлдсөн тул буулгаад зогсолт хийсэн. Ажил удаашралтай хийсэн тул 2023 оны 1.1 тэрбум төгрөг татагдсан. Ажлын гүйцэтгэл 10% хийсэн.	30
145	Дотуур байрны барилга, 100 ор /Завхан, Цэцэн-Уул сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	30%	100%	1,881.0	УТ	1881.00	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, БШУГ	Барлгын ажил 2023 оны 3-сарын 27-ны өдрөөс эхэлж, 70%-тай хийгдэж байна. Халаалт оруулж, дотор заслын ажил хийгдэж байна.	70
146	Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Завхан, Баянтэс сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	10%	100%	1,000.0	УТ	1000.00	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, БШУГ	320 хүүхдийн сургууль, спорт заалны барилгын гүйцэтгэгчээр "Цэнхэр тэнгэрийн орон оч" ХХК шалгаран гэрээ байгуулан 1, 2-р давхрын өрлөг хийгдсэн. Ажлын гүйцэтгэл 30% хийсэн.	30

147	Ерөнхий боловсролын сургуулийн хөгжмийн танхимын тоног төхөөрөмж /Завхан/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	100%	100%	369.3	УТ	369.30	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, БШУГ	Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд 904,3 сая төгрөг батлагдаж Завхан аймгийн 24 сумын 29 сургуулийн хөгжмийн кабинетыг иж бүрэн хөгжмийн зэмсэг хэрэглэээр бүрэн хангасан бөгөөд үлдэгдэл 369,3 сая төгрөгийн санхүүжилтийг 2023 онд олгосон.	100
148	Хөгжимт жүжгийн театрын барилга, 800 суудал /Завхан, Улиастай сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	80%	100%	513.2	УТ	513.20	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, СУГ	ХЖТ-ын барилгын ажил 2023 оны 5-р сарын 1-с ажил эхэлж, төв хаалганы хэсгийн 1 ба 2 давхрын гадна шилэн фасад, гадна зам талбайн тохжилтын ажлууд хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 80% хийсэн.	70
149	Соёлын төвийн барилга, 200 суудал /Завхан, Идэр сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	100%	100%	223.3	УТ	223.30	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, СУГ	2022 онд барилгыг барьж, ашиглалтад өгсөн. УИХ-ын 88-р тогтоолын дагуу 2023 онд улсын төсөвт үнийн өсөлтийн нэмэгдэл санхүүжилт батлагдаж гүйцэтгэгч санхүүжилт авсан. Ажлын гүйцэтгэл 100% хийсэн.	100
150	Соёлын төвийн барилга, 200 суудал /Завхан, Түдэвтэй сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	60%	100%	333.2	УТ	333.20	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, СУГ	УИХ-ын 88-р тогтоолын дагуу 2023 онд улсын төсөвт үнийн өсөлтийн нэмэгдэл санхүүжилт батлагдсан. Гүйцэтгэгч "Этүгэн жим" ХХК 2023 оны ажил хийгдсэн. Угсралтын ажил 70% хийсэн.	70
151	Соёлын төвийн барилга, 200 суудал /Завхан, Нөмрөг сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	40%	100%	411.8	УТ	411.80	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, СУГ	УИХ-ын 88-р тогтоолын дагуу 2023 онд улсын төсөвт үнийн өсөлтийн нэмэгдэл санхүүжилт батлагдсан. Гүйцэтгэгч "Ар Си Ди" ХХК 2023 оны 5-р сараас ажил эхлэж 2-р давхрын металл багана, дам нуруу, сандвич хучилт, гадна фасад хийгдсэн. Ажлын гүйцэтгэл 70% хийсэн	70
152	Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн Загастайн давааны 67 км хатуу хучилттай авто замын дуусгал /Завхан/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	100%	100%	164.5	УТ	164.50	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ	Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн Загастайн давааны 67 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг 2022 онд ашиглалтад хүлээлгэн өгсөн. 2023 онд Ковидын үеийн үнийн дүнгийн зөрүү батлагдаж, нэмэлт гэрээ байгуулан санхүүжилтийг олгосон.	100
153	Гудамж төсөл /Завхан, Улиастай сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	90%	100%	90.8	УТ	90.80	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, СЗДТГ	Тус барилгын ажлыг 2022 онд ашиглалтад хүлээлгэн өгсөн. 2023 онд Ковидын үеийн үнийн дүнгийн зөрүү батлагдаж, нэмэлт гэрээ байгуулан санхүүжилтийг олгосон.	100
154	Нисэх буудлын авто замын уулзвараас сумын төв хүртэлх авто зам, 6.7 км, сумын төвийн хатуу хучилттай авто зам /Завхан, Алдархаан сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	100%	100%	74.1	УТ	74.10	АЗДТГ-ын ХБТХОХ	СТСХ	Тус барилгын ажлыг 2022 онд ашиглалтад хүлээлгэн өгсөн. 2023 онд Ковидын үеийн үнийн дүнгийн зөрүү батлагдаж, нэмэлт гэрээ байгуулан санхүүжилтийг олгосон.	100
155	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 3 км /Завхан, Их-Уул сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	80%	100%	26.7	УТ	26.70	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, СЗДТГ	2023 онд Ковидын үеийн үнийн дүнгийн зөрүү батлагдаж нэмэлт гэрээ байгуулан санхүүжилт олгосон. 2024 онд санхүүжилт батлуулж үлдэгдэл ажлыг хийж дуусгах шаардлагатай.	90
156	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Завхан/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	80%	100%	198.0	УТ	198.00	АЗДТГ-ын ХБТХОХ	ХХААГ	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хэрэгжиж буй "Шинэ хөдөө" төслөөс хадлангийн иж бүрэн тоног төхөөрөмж болох трактор, хаман боогч, хадуур, тармуур, үрлэгч, анжис тус бүр нэг, нэг ширхэг, арьс нэхий, сур элдэх тоног төхөөрөмж халимлах машин, элдэх машин, зүлгэх машин, талхих машин, дэвтээх хэрэгсэл тус бүр 6 ширхэг, цахилгааны иж бүрдэл 6 ширхэг, тоног төхөөрөмжүүдийг сумдад хүлээлгэж өгсөн.	100

157	Цахилгаан дамжуулах агаарын шугам /Завхан, Улиастай сум, 21 дүгээр зуун хороолол/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	80%	100%	383.1	УТ	383.10	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, АУЭХС ТӨХК	Улиастай сумын Өлзийт багийн "21-р зуун орон сууцны хороолол"-ын 1.8 км цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээ, 3ш дэд станцын барилга, тоног төхөөрөмж угсрах ажлыг гүйцэтгэж ашиглалтад оруулсан.	100
158	Сум дундын эмнэлгийн амбулаторийн барилга /Завхан, Завханмандал сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	60%	100%	521.2	УТ	521.20	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, ЭМГ	УИХ-ын 88-р тогтоолын дагуу 2023 онд улсын төсөвт үнийн өсөлтийн нэмэгдэл санхүүжилт батлагдсан. 2022 онд "Богч констракшн" ХХК нь 1, 2-р давхрын гадна, дотор шавардлага хийсэн. ГХБХБГ-аас барилгын ажлыг эхлүүлэх, эрчимжүүлэх талаар 2023 оны 6 дугаар сарын 02 өдрийн 242 тоот албан бичгийг гүйцэтгэгч байгууллагад хүргүүлсэн боловч ажил хийгдээгүй байна.	50
159	Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Завхан, Яруу сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	20%	100%	1,716.9	УТ	1716.90	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, ЭМГ	Эрүүл мэндийн төвийн барилгын суурийн ажил 2022 онд хийгдэж технологийн зогсолт хийсэн. 2023 онд "Дайчин хүлэг" ХХК нь 1, 2-р давхрын гадна дотор шавардлага хийсэн. Ажлын гүйцэтгэл 60% хийсэн.	50
160	Нэгдсэн эмнэлгийн барилгын дотор шугам сүлжээ, барилгын их засвар /Завхан, Тосонцэнгэл сум/	2023 он	Ажлын гүйцэтгэл, хувь	80%	100%	28.7	УТ	28.70	АЗДТГ-ын ХБТХОХ	ГХБХБГ, ЭМГ	Тосонцэнгэл сумын нэгдсэн эмнэлгийн барилгын дотор шугам сүлжээ, барилгын их засвар бүрэн хийгдэж, ашиглалтад орсон.	100
